

**«БНМАУ, БНХАУ-ЫН ХООРОНДЫН ЭДИЙН ЗАСАГ БА СОЁЛЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР» БАЙГУУЛАГДСАН НЬ:
ҮЙЛ ЯВЦ, АЧ ХОЛБОГДОЛ**

*Дамдиндоржийн Базардорж
ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, доктор Ph.D
Email:bazardorjd@mas.ac.mn*

Сүүлийн жилүүдэд Монгол, Хятадын харилцааны түүхэн тоймыг нийтэлж буй албан байгууллагуудын цахим хуудас, лавлахуудад нэгэн хачирхалтай зүйл ажиглагдах болсон нь юу хэмээвээс, Монгол, Хятадын харилцааны чухал үйл явдлуудын он цагийн жагсаалтад 1952 оны «БНМАУ, БНХАУ-ын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр» дурдагдахгүй, орхигдох төлөвтэй болсон үзэгдэл юм. Олон нийтийн цахим орчин дахь сэдэвтэй холбогдох мэдээ, лавлахуудад ч ийм байдал түгээмэл. Үүнд гайхан эргэлзэж, ахин дахин нягтлавч байдал үнэхээр дээрх мэт аж. Та бүхэн анзаарч нэг хараарай.

Энэ чухам юуг илэрхийлнэ вэ? Өнгөрсөн социалист харилцаанд илэрсэн ч өдгөө орхигдон гээгдэж буй жам ёсны үзэгдэл гэж үүнийг үзэж болох уу, эсхүл?

Иж бүрэн стратегийн түншлэлийн суурь

Өнөөдөр Монгол, Хятад хоёр улсын харилцаа, хамтын ажиллагаа Иж бүрэн стратегийн түншлэлийн түвшинд хүрч бүх салбарт эрчимжиж, түүхэн дэх харилцааны хамгийн таатай, хамтын ажиллагааны хамгийн цараатай цаг үедээ өрнөж байна. Хоёр улсын харилцаа, хамтын ажиллагаа ийм өндөр түвшинд байгаа нь чухамдаа БНХАУ-ын дарга Ши Жиньпин Монгол Улсад 2014 оны 8 дугаар сард айлчлах үеэр гаргасан төрийн тэргүүдийн хамтарсан тунхгаас эхтэй. Энэ нь 2011 онд Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр Монгол, Хятадын харилцаа Стратегийн түншлэлийн түвшинд хүрснийг зарласнаас хойш ердөө гуравхан жилийн дараах үйл явдал байлаа. Харин Стратегийн түншлэл маань 2003 оны 6 дугаар сард БНХАУ-ын дарга Ху Жиньтао-гийн Монгол Улсад хийсэн төрийн айлчлалаар биежсэн «Монгол, Хятадын сайн хөршийн, харилцан итгэсэн, түншлэлийн харилцаа»-г өндөрсгөн байгуулагдсан билээ. Эдгээр бол шинэ цагийн Монгол, Хятадын харилцааны хөгжлийн үе шатыг тодорхойлсон чухал айлчлалууд ба голлох баримт бичгүүд болно. Чухамдаа харилцаа, хамтын ажиллагааны түвшин харьцангуй богино хугацаанд шат ахин өндөрссөн нь харилцаа, хамтын ажиллагааны тодорхой зарчимтай байсны үр дүн. Тэрхүү зарчим 1994 оны «Монгол Улс, БНХАУ-ын найрсаг

харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ»-нд гүн гүнзгий тусгагдсан юм. 1994 оны гэрээ бол Хүйтэн дайнаас хойших шинэ цаг үед хөрш хоёр улсын харилцааны үндсэн зарчим, хэм хэмжээг тодорхойлсон суурь гэрээ болдог. Тэрхүү суурь гэрээ нь 1960 оны 5 дугаар сарын 31-ний өдөр байгуулагдсан «БНМАУ, БНХАУ-ын хоорондын найрамдал, харилцан туслалцах тухай гэрээ»-г шинэ нөхцөлд нийцүүлэн шинэчилж, зарчмын заалтуудыг уламжлан авч байгуулагдсан билээ. Иймийн тул 1994 оны гэрээнд 1960 оны гэрээний ерөнхий зарчим нь суурь болж өгсөн байна. Хоёр улсын харилцааны түүхэнд харилцаа, хамтын ажиллагааны зарчим, хэм хэмжээг анхлан тодорхойлж өгснөөрөө 1960 оны гэрээ онцгойлон тэмдэглэгдсээр иржээ. Цаашилбал, 1960 оны гэрээ нь 1952 оны «БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр», түүнийг үндэслэн хийгдсэн тодорхой салбарууд дахь хоёр талт хамтын ажиллагааны олон хэлэлцээрүүд ба тэдгээрийн хэрэгжилтийн хүрсэн үр дүнд суурилан байгуулагдсан байдаг.

Чухамдаа энэ логикт тулгуурлахад, өнөөдрийн Иж бүрэн стратегийн түншлэлийн түвшинд хүрсэн хоёр улсын харилцаа, хамтын ажиллагаанд 1952 оны хэлэлцээрийн үзэл санаа хадгалагдсаар байгаа бөгөөд цагийн шалгуур сорилыг давж, ямар ч нөхцөлд амьтай байж өнөөдөрт хүрснийг бид урьдаар харж болох байна.

Хэлэлцээр байгуулагдах урьдач нөхцөл

«БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр»-ийн урьдач нөхцөлийн чухал үйл явдлын тэргүүнд БНХАУ байгуулагдсан явдал орно. Хятад орон өнгөрсөн зууны эхэн хагаст сунжирсан самуунд үймэн бужигнасны эцэст 1949 оны 10 дугаар сарын 1-ний өдөр ХКН-аар удирдуулсан социалист БНХАУ-ыг тунхаглав. Чингэснээр Монгол, Хятад хоёрт ижил засаг тогтож, мөн сарын 16-нд дипломат харилцааг байгуулав. Дагалдаад БНМАУ-ын гадаад орчин бүхэлдээ дэлхийн социалист системээр хүрээлүүлэв. Шинээр тунхаглагдсан БНХАУ урьдын Гоминдан намаар удирдуулсан ДИУ-ын гадаад бодлогыг үгүйсгэж, гадаадтай байгуулсан бүхий л гэрээ, хэлэлцээрийг нь хүлээн зөвшөөрөхгүйгээ зарлаж, гадаад бодлогыг шинэ зарчмаар хэрэгжүүлж эхлэв. Энэ хүрээндээ анхны гадаад гэрээг хөгжлийн онол, замнал ижил ЗХУ-тай байгуулсан нь даруй 1950 оны 2 дугаар сарын 4-нд Москва хотноо гарын үсэг зурж баталгаажуулсан «БНХАУ, ЗХУ-ын найрамдал, холбоо, харилцан туслалцах гэрээ» байв. Энэ гэрээг үзэглэх явцад Монголын асуудал хөндөгдсөн байлаа. Ялангуяа, гэрээг байгуулсан даруйдаа тус хоёр улсын Гадаад явдлын яамд хооронд тусгайлан ноот солилцсон нь БНМАУ-ын хувьд нэн ач холбогдолтой чухал үйл явдал байв. БНХАУ нэгэнт ДИУ-ын гадаадтай байгуулсан гэрээ, хэлэлцээр, амлалтуудыг хүчингүйд тооцсон

нь ДИУ-аас хүлээн зөвшөөрсөн БНМАУ-ын тусгаар тогтнолыг үгүйсгэж болохуйц хоёрдмол байдлыг үүсгэсэн тул уг ноотоор тусгайлан БНМАУ-ын талаарх БНХАУ-ын баримтлах албан ёсны байр суурийг бататгаж өгсөн байна. БНХАУ нь 1945 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн Монголын бүх ард түмний тусгаар тогтнолын төлөөх санал асуулгын үр дүн ба 1949 оны 10 дугаар сарын 16-нд БНМАУ, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосныг үндэс болгон БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч байгаагаа уг ноотоор нотолсон юм. Энэ бол Монголын тусгаар тогтнолын асуудал түүхэн ямар ч нөхцөлд аль ч цагт Хятадын зүгээс эргэн сөхөгдөхгүйгээр бүрмөсөн шийдэгдсэн түүхт явдал болсон билээ. Чухамдаа Монгол, Хятад хоёр улс орчин үеийн олон улсын харилцааны хэм хэмжээ, зарчмын дагуу эрх тэгшээр харилцаа, хамтын ажиллагааг өргөн хүрээнд хөгжүүлэх суурийг мөн талбиж өгсөн юм. Үүний дараахан 1950 оны зун БНМАУ, БНХАУ харилцан Элчин сайдуудыг томилон суулгаснаар хоёр улсын харилцааны шинэ үе өргөн үүдээ нээсэн билээ.

Дээрх бүгд хоёр улсын Засгийн газар хооронд анхны албан ёсны хэлэлцээр болох «БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр» байгуулагдах таатай нөхцөлийг бүрдүүлж өгсөн юм.

Хэлэлцээр байгуулагдсан нь

1952 он бол Монгол, Хятадын харилцаанд онцгой үйл явдлуудаар дүүрэн жил болжээ. Тус жилийн 9 дүгээр сарын 28-наас 10 дугаар сарын 17-ны өдрүүдэд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбал тэргүүтэй Монголын төлөөлөгчид БНХАУ-д албан ёсны айлчлал хийв. Энэ айлчлал БНМАУ-аас БНХАУ-д хийсэн анхны Засгийн газрын тэргүүний айлчлал, мөн БНХАУ байгуулагдсанаас хойш тус улсын хүлээж авсан анхны гадаад орны Засгийн газрын тэргүүний айлчлал болж Монгол, Хятадын аль алиных нь дипломатын түүхэнд чухал байр суурийг эзэлдэг юм. 20 гаруй хоног үргэлжилсэн айлчлалаар Ю.Цэдэнбал БНХАУ-ын дарга Мао Зэдун ба бусад нам, төрийн удирдлагуудтай дахин давтан учирч, олон хот мужуудаар зочилж, хоёр улсын найрамдал нөхөрлөлийг бататгах ба найрсаг харилцааг чухалчилсан уулзалт, арга хэмжээнүүдэд оролцож билээ. Гэхдээ энэ айлчлалын гол үр дүн бол 10 дугаар сарын 4-ний өдөр БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбал, БНХАУ-ын Ардын төв Засгийн газрын Ерөнхий сайд Жоу Энълай нар «БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр»-т гарын үсэг зурсан явдал байв. Энэ бол хоёр улсын Засгийн газрын түвшний анхны хамтын ажиллагааны баримт бичиг болж, 1949 онд дипломат харилцаа тогтоосон, 1950 онд харилцан элчин

сайд суулгасан зэрэгтэй хамтатган үзэхүйц хоёр талын харилцааны эхний жилүүдэд илэрсэн улс төрийн томоохон ололт, амжилт болсон юм.

Хэлэлцээрийг хоёр талаас асар их ач холбогдол өгч, сайтар төлөвлөн боловсруулж, хоёр улсын ард түмнийг өргөн хүрээнд хамарсан баяр ёслол ба найрамдал нөхөрлөлийн арга хэмжээний халуун дулаан уур амьсгал дунд байгуулсан байдаг. Гарын үсэг зурсан өдөр ба Монголын төлөөлөгчдийн айлчлал хэрэгжсэн өдрүүд нь БНХАУ байгуулагдсаны 3 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх улсын баяртай нь зэрэгцсэн бол БНМАУ-д «Монгол, Хятадын найрамдлын 10 хоног» хэмээх хоёр улсын нөхөрлөл, найрамдлыг сурталчилсан өргөн цараатай соёлын арга хэмжээг мөн өдрүүдэд улс орон даяар зохион байгуулж байлаа.

Хэлэлцээр ийнхүү байгуулагдсан нь жил гаруйн хугацаанд үргэлжилсэн хэд хэдэн шатанд авч үзэж болохуйц бэлтгэл ажлын үр дүн гэж үзэж болох юм. Ялангуяа Монголын тал, маршал Х.Чойбалсан БНХАУ-тай Засгийн газрын түвшинд хамтран ажиллах, хэлэлцээр байгуулахыг онц чухалчлан байсан юм. БНХАУ-тай Засгийн газрын түвшинд хэлэлцээр байгуулах явдал 1950 оны сүүлчээс эхлэн яригдаж улмаар 1951 оны 9 дүгээр сар гэхэд БНМАУ-ын Засгийн газраас БНХАУ-тай Засгийн газрын түвшинд байгуулах анхны хэлэлцээрийн төслийг батлав. Тэр нь гагцхүү соёлын салбарт хамтран ажиллах зорилго бүхий «БНМАУ, БНХАУ-ын хооронд соёлын талаар хамтран ажиллах тухай хэлэлцээр»-ийн төсөл бөгөөд уг төслөөр хэлэлцээрийг Ерөнхий сайдын орлогчийн түвшинд байгуулахаар тусгасан байлаа¹.

Үүнтэй зэрэгцэн хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосноос хойш Худалдааны яамд хооронд ба зарим аж ахуйн нэгжүүдийн хооронд тусгай асуудлаарх худалдааны хэлэлцээрүүд байгуулагдаж байв. Тухайлбал, 1951 оны 4 дүгээр сарын 26-нд Худалдааны яам хооронд «Адууны хэлэлцээр» байгуулагджээ. 1951 оны 10 дугаар сарын 12-ны өдөр мөн Худалдааны яамд хооронд «Дүнсэн тамхины хэлэлцээр»-т гарын үсэг зурав. Мөн оны 12 дугаар сарын 29-нд БНМАУ-ын Хоршоодын төв холбоо, БНХАУ-ын Цайны аж ахуйн компани хооронд «1952 онд худалдаалах цайны тухай хэлэлцээр» байгуулагджээ. Эдгээрийг өргөтгөж, Худалдааны ерөнхий хэлэлцээрийг Засгийн газрын түвшинд байгуулах тухай асуудал яригдаж байв. Ерөнхийлбөл, Монголын талаас анхандаа БНХАУ-тай Соёл ба Худалдааны талаар Засгийн газрын түвшинд тус тусдаа хэлэлцээрийг байгуулах оролдлого өрнүүлж, аль алинд нь ач холбогдол өгч идэвхийлж байсан хэмээвэл зүйтэй.

Хятадын зүгээс ч эдийн засаг, худалдааны ба соёл, гэгээрлийн талаар харилцах саналыг ихээр дурдах болсон нь албаны хүмүүсийн ярианы тэмдэглэлээс тодорхой харагдаж байна. Эцсийн бүлэгт Монголын тал хоёр

¹ Гадаад харилцааны төв архив. Х-4, Д-19, ХН-381, хуудас 2-4

талын хүсэл сонирхол хийгээд харилцааны нөхцөл байдлыг харгалзан БНХАУ-тай Засгийн газрын түвшинд худалдаа, соёлын асуудлыг хамтатгасан ерөнхий хэлэлцээр байгуулахаар болсон байна. Улмаар энэ талаарх Гадаад явдлын сайд Н.Лхамсүрэнгийн мэдэгдлийг сонсоод МАХН-ын Улс төрийн товчоо 1952 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 7/13 тоот тогтоолоор БНХАУ-тай Засгийн газрын түвшинд байгуулах хэлэлцээрийн нэрийг «БНМАУ ба БНХАУ-ын хооронд эдийн засаг, соёл боловсролын талаар хамтран ажиллах хэлэлцээр» гэж тогтох нь зүйтэй хэмээн баталж, Бээжинд суугаа Элчин сайдын ямаараа дамжуулан Хятадын талд хүргүүлж танилцуулахаар болжээ. Энэ дагуу Элчин сайд Б.Жаргалсайхан 1952 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр Хятадын гадаад явдлын яамны орлогч сайд Жан Ханфүтай уулзаж, хоёр улсын Засгийн газар хооронд ерөнхий хэлэлцээр байгуулах саналыг тавьж, БНХАУ-ын Засгийн газрын саналыг авахаар өөрийн талын бэлтгэсэн хэлэлцээрийн төслийг гардуулсан байна. Чингэхдээ хэрэв Хятадын тал хэлэлцээрийн төслийн үндсэн зарчмуудыг хоёр этгээдэд харилцан ашигтай гэж зөвшөөрвөл БНМАУ-ын Засгийн газар БНХАУ-тай энэ хэлэлцээрийг байгуулахын тулд өөрийн төлөөлөгчийг Бээжинд ирүүлэхэд бэлэн байгааг мэдэгдсэн байна. Мөн энэ хэлэлцээрийг байгуулах тухай журам ба багцаалсан хугацааны талаар БНХАУ-ын Засгийн газрын саналыг мэдэхийг хүссэн байна². Ийнхүү хоёр улсын хооронд Засгийн газрын түвшинд хамтын ажиллагааны ерөнхий хэлэлцээр байгуулах ажил албажиж, эрчимжиж эхэлжээ. Харамсалтай нь яг энэ үед 1952 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр маршал Х.Чойбалсан нас барсан нь хэлэлцээр байгуулах асуудал хэсэг хугацаанд орхигдоход хүрчээ. Гэсэн ч мөн оны 6 дугаар сараас хэлэлцээрийн асуудал сэргэн БНХАУ-д дахин яригдаж эхлэв. БНХАУ-ын ГЯЯ дээр Монголын талаас хүргүүлсэн хэлэлцээрийн төсөл ба уг хэлэлцээрийг байгуулах журам, хугацааны асуудлыг хоёр удаа хэлэлцэж, Засгийн газрынхаа саналыг тусгаад Монголын талд ирүүлсэн байна. БНХАУ-ын Засгийн газрын ирүүлсэн байр суурь, саналыг БНМАУ-ын Засгийн газар хэлэлцээд хүлээж авав.

Түүнийг нь МАХН-ын УТТ хэлэлцээд 1952 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 81/174 дүгээр тогтоолоор баталснаар уг хэлэлцээрийн албан ёсны нэр ба байгуулагдах газар хийгээд хугацааны товыг эцэслэжээ. Мөн тогтоолоор БНХАУ-д очиж хэлэлцээрийг байгуулах Монголын талын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг баталж, ахлагчаар нь Ю.Цэдэнбалыг томилов. Хоёр талын Ерөнхий сайдын түвшинд Бээжин хотноо гарын үсэг зурсан уг хэлэлцээрийг 1952 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр БНМАУ-ын Их хурлын тэргүүлэгчид³, мөн оны 11 дүгээр сарын 15-нд БНХАУ-ын Ардын төв Засгийн газар тус тус соёрхон баталсан байдаг. Ингээд хоёр талын

² Гадаад харилцааны төв архив. Х-5, Д-2, ХН-85

³ Гадаад харилцааны төв архив. Х-119, Д-1, ХН-114-4, Хуудас 150. БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг. 1952.11.3.

дээд байгууллагуудын батламж бичгүүдийг Улаанбаатар хотноо 1952 оны 12 дугаар сарын 29-ний өдөр Монголын талаас Гадаад харилцааны сайд Н.Лхамсүрэн, Хятадын талаас БНХАУ-аас БНМАУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Заяат нар солилцсоноор⁴ Монгол, Хятадын Засгийн газрын түвшинд байгуулсан анхны хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн билээ.

Энэ хэлэлцээр бол Монголын хувьд Засгийн газрын түвшинд гадаад оронтой байгуулсан хоёр дахь хэлэлцээр болдог. Үүний урьд 1946 онд ЗХУ-тай яг ийм «Эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр»-ийг байгуулж байлаа. Харин БНХАУ-ын хувьд Бээжин хотноо байгуулсан Засгийн газар хоорондын анхны хэлэлцээр, мөн эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах гэдэг ерөнхий шинжтэйгээр гадаадтай байгуулсан анхны хэлэлцээр болно. Яг ийм ижил нэртэй ерөнхий хэлэлцээрийг БНХАУ хойтон жил нь БНАСАУ-тай байгуулсан юм.

Хэлэлцээрийн шинж чанар

Дэлхийн хоёрдугаар их дайны дараа социалист систем бүрэлдэн тогтож, түүнд багтсан их бага улс орнууд өөр хоорондоо дипломат харилцааг өрнүүн дэлгэрээр байгуулж, улмаар Засгийн газрын түвшинд анхны хэлэлцээрүүдийг байгуулах явдал эрчтэй өрнөсөн байна. Ийм хүрээнд БНМАУ 1960-аад он хүртэлх хугацаанд ялангуяа 1950-иад оны хоёрдугаар хагаст социалист улсуудтай дипломат харилцааг тогтоож, Засгийн газрын түвшний анхны хоёр талт хэлэлцээрүүдийг мөн идэвхийлэн байгуулсан байна. БНМАУ-аас гадаад улсуудтай байгуулсан Засгийн газрын түвшний хоёр талт анхны хэлэлцээрүүдийг харахад “Эдийн засаг ба соёл”-ын гэх өргөн хүрээг хамарсан ерөнхий шинжтэй хэлэлцээрийг гагцхүү ЗХУ, БНХАУ-тай л хийсэн байна. Бусад улстай Засгийн газрын түвшинд анхлан байгуулсан баримт бичгүүд нь аль нэгэн салбарт хамтран ажиллах шинжтэй байсан нь дийлэнхдээ соёлын салбарт хамтран ажиллах хэлэлцээрүүд ажээ. Соёлын салбарт хамтран ажиллах хэлэлцээр байгуулсан улсуудыг дурдвал, Албани /1955.8.6/, Румын /1956.5.8/, Умард Солонгос /1956.5.14/, Ардчилсан Герман /1957.8.13/, Чехословак /1957.4.8/, Болгар /1957.9.3/, Унгар /1957.10.9/, Ардчилсан Вьетнам /1958.2.17/, Польш /1958.12.23/, Куба /1960.12.7/ болно⁵.

Иймээс БНМАУ ба БНХАУ-ын хооронд байгуулсан энэхүү хэлэлцээр бол БНМАУ-аас социалист бусад улс орнуудтай Засгийн газрын түвшинд байгуулсан шиг аль нэгэн салбарын асуудлыг хөндсөн явцуу хүрээнд үйлчлэх тусгай хэлэлцээр биш, харин хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны

⁴ Гадаад харилцааны төв архив. Х-119, Д-1, ХН-114-4, Хуудас 156-157. БНМАУ ба БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийн батламж бичгүүдийг солилцсон тухай протокол. 1952.12.29.

⁵ БНМАУ-ын Гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхэтгэл. I, II боть. УБ., 1964, 1966

бүхий л салбарыг агуулсан суурь хэлэлцээр болсон гэдгээрээ ихээхэн онцлогтой, бас цаашдын харилцаанд чухал ач холбогдолтой болсон гэдгийг бас нэгэн удаа тодотгох хэрэгтэй болж байна.

Ерөөсөө энэхүү хэлэлцээрийг байгуулсан явдлыг тухайн цагт хоёр улсын нам, төрөөс маш ихээр чухалчлан үзэж, хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны суурь байж, интернационалист зарчмыг үндэс болгосон ах дүүгийн чин сэтгэлийн харилцааны гэрч хэмээн онцлон дурдаж байв. Энэ үзэл санаа ялангуяа хэлэлцээрт гарын үсэг зурах ёслолын үеэр хоёр улсын Ерөнхий сайдын хэлсэн үгнээс тодорхой илэрч байв. Тэр тусмаа БНМАУ-ын Ерөнхий сайд Ю.Цэдэнбалын хэлсэн үгэнд нэн тодорхой илэрч гарсан билээ⁶.

Түүний хэлсэн үгийн агуулгад, Монгол, Хятадын ард түмэн найрамдал нөхөрлөлийг эрхэмлэсээр ирсэн ч энэ хүртэлх хугацаанд харилцан биесээ таньж завдсангүй. Шалтгаан нь Монголын феодалуудын, Хятадын газрын эздийнхний, тэднээр дамжсан гаднын империалистуудын, дарлагч ангийнхны зориуд үүтгэн гаргасан хар хор гээд, одоо ижил засаг тогтсон тул уг хэлэлцээрийг байгуулав. Иймээс ангич, намч байр сууринаас марксизм, ленинизмийн үзэл санаа, зарчмыг удирдлага болгон Монгол, Хятадын харилцааг хөгжүүлэх шинэ цаг ирж буйг онцлон тэмдэглэсэн байдаг.

Үнэхээр ч түүний хэлснээр энэхүү суурь хэлэлцээр дээр үндэслэн дараа дараалан байгуулагдсан хоёр талт олон хэлэлцээрүүд ба тэдгээрийн хэрэгжилт нь хоёр ард түмний интернационализмын зарчим дээр суурилсан ах дүүгийн өрнүүн харилцаа болж цаашид эрчимтэй хөгжсөнийг Та бид мэднэ.

1953, 1962 онуудад хоёр талаас хамтран энэхүү хэлэлцээр байгуулагдсаны 1 жилийн ба 10 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн байдаг. 1953 оны 8 дугаар сарын 31-ний өдөр МАХН-ын Төв хорооны Нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөний 415 дугаар тогтоол гарч, хэлэлцээр байгуулсны 1 жилийн ойг БНХАУ-ыг тунхагласны 4 жилийн ойтой хамтатган тэмдэглэн өнгөрүүлэхээр болж, ажлын төлөвлөгөөг гаргаж байлаа⁷. 1962 онд хэлэлцээрийн 10 жилийн ойг өргөн хүрээнд хоёр талд тэмдэглэсэн байна. 1962 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр «БНМАУ ба БНХАУ-ын хооронд эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр байгуулагдсаны 10 жилийн ой, БНХАУ-ыг тунхагласны 13 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай» МАХН-ын Төв хорооны Нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөний 466 дугаар тогтоол гарч, ойг тэмдэглэх хүрээнд Монгол, Хятадын найрамдлын 10 хоногийг улс орон даяар зохион байгуулж, Төв аймгийн Лүн сумын

⁶ Гадаад харилцааны төв архив. Х-5, Д-2, ХН-89, хуудас 32-34. БНМАУ ба БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээрт гарын үсэг зурахад БНМАУ-ын Ерөнхий сайд Ю.Цэдэнбалын хэлсэн үг.

⁷ Монгол-Хятадын соёл шинжлэх ухааны харилцаа. Тэргүүн боть. УБ., 2021, тал 45-46. БНХАУ-ыг тунхагласны 4 жилийн ой ба БНМАУ, БНХАУ-ын хооронд эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах тухай хэлэлцээр байгуулсны нэг жилийн ойг өнгөрүүлэх тухай МАХН-ын Төв хорооны Нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөний 415 дугаар тогтоол. 1953.8.31.

«Энхтуул» нэгдлийг Монгол-Хятадын найрамдлын нэрэмжит болгож байлаа⁸. Нам, төрийн удирдагчдын хооронд харилцан баярын мэндчилгээ дэвшүүлж байв. ХКН-ын Төв хорооны дарга Мао Зэдун, БНХАУ-ын дарга Лю Шаоци, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Жоу Эньлай нараас нэр хамтатган МАХН-ын Төв хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын СнЗ-ийн дарга Ю.Цэдэнбал, БНМАУ-ын АИХТ-ийн дарга Ж.Самбуу нарт баярын мэндчилгээ ирүүлсэн⁹ бол Ю.Цэдэнбал, Ж.Самбуу нараас мөн адил нэр хамтатгасан баярын мэндчилгээг хүргүүлж байсан юм¹⁰. БНМАУ-ын ГЯЯ-ны сайд П.Шагдарсүрэн, БНХАУ-ын ГЯЯ-ны сайд Чэнь И нар харилцан баярын мэндчилгээг дэвшүүлж байлаа¹¹. Эдгээр баярын мэндчилгээ хоёр улсын харилцааг харьцангуй богино хугацаанд эрчимтэй хөгжүүлэхэд уг хэлэлцээр чухал үүрэг гүйцэтгэсэн ба гүйцэтгэж буйг онцолж, түүхэн ач холбогдлыг нь өндрөөр үнэлсэн юм. Ерөөсөө, Монгол, Хятадын социализмын үеийн харилцааны түүхэнд хоёр талаас хамтран байгуулсан аль нэгэн гэрээ хэлэлцээрийн ойг онцлон тэмдэглэж байсан түүх үүнээс өөр үгүй юм.

Хэлэлцээрийн агуулга, хэрэгжилт

Хэлэлцээр оршил, гурван зүйлтэй. Тунхгийн шинжтэй, тун ерөнхий. Гол агуулга нь хоёрдугаар зүйлд буй. Оршил хэсэгт “... хоёр улсын хооронд эдийн засаг, соёлын нягт хамтын ажиллагаа тогтоох явдал нь тус хоёр орны ард түмний эрх ашигт бүрэн нийцэж, тэдгээрийн хоорондын найрамдалт харилцааг улам цаашид хөгжүүлэн бэхжүүлэх явдалд чухал ач холбогдолтой болохыг анхааран үзэж, энэ зорилгын үүднээс уг хэлэлцээрийг байгуулах...” болсныг тэмдэглээд **Нэгдүгээр зүйлд** “Хэлэлцэгч хоёр этгээд нь БНМАУ ба БНХАУ-ын хооронд эдийн засаг, соёл, гэгээрлийн талаар хамтын ажиллагааг тогтоож хөгжүүлэн бэхжүүлэхээр хэлэлцэн тогтов” хэмээн дурдсан байна. Харин **хоёрдугаар зүйлд** хэлэлцээр байгуулагдсанаар цаашид хамтын ажиллагааны ямар алхмууд хийгдэж болохыг тусгаж өгөхдөө “... энэ хэлэлцээрийг үндэслэн, мөн үүнийг биелүүлэх журмаар БНМАУ ба БНХАУ-ын аж ахуй, худалдаа, соёл – гэгээрлийн зохих албан газруудын хооронд жич тодорхой хэлэлцээрүүд тогтоогдож байх болно” хэмээн дурджээ. Чухамдаа энэ заалтыг үндэслэн 1960-аад оны эх хүртэлх хугацаанд хоёр улсын харилцааг хөгжүүлэхэд чухал ач холбогдол бүхий тодорхой салбарын харилцааны асуудлыг зохицуулсан олон гэрээ, хэлэлцээрүүд байгуулагдсан байдаг. Тухайлбал,

⁸ Монгол-Хятадын соёл шинжлэх ухааны харилцаа. Тэргүүн боть. УБ., 2021, тал 280. БНМАУ ба БНХАУ-ын хооронд эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах тухай хэлэлцээр байгуулагдсаны 10 жилийн ой, БНХАУ-ыг тунхагласны 13 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай МАХН-ын Төв хорооны Нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөний 466 дугаар тогтоол. 1962.9.7.

⁹ Гадаад харилцааны төв архив. Х-5, Д-2, ХН-184, хуудас 35-36.

¹⁰ Гадаад харилцааны төв архив. Х-5, Д-2, ХН-184, хуудас 29-30.

¹¹ Гадаад харилцааны төв архив. Х-5, Д-2, ХН-184, хуудас 41, 43.

«Шуудан солилцох тухай Холбооны яам хоорондын хэлэлцээр» /1953.1.16/, «Худалдааны бус зээлийн хэлэлцээр» /1953.2.24/, Жил бүрийн бараа солилцоо ба тооцоо нийлэх хэлэлцээрүүд /1953 оноос/, Жил бүрийн соёлын хамтын ажиллагааны хөтөлбөрүүд /1954 оноос/, «Радио нэвтрүүлгийн талаар хамтран ажиллах тухай хэлэлцээр» /1955.12.21/, «Шуудангийн илгээлтийг солилцох тухай хэлэлцээр» /1956.2.25/, «БНМАУ-д эдийн засаг, техникийн тусламж үзүүлэх тухай хэлэлцээр» /1956, 1958, 1960/, «Соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр» /1958.2.21/, «Кино зургуудыг харилцан солилцож гаргах эрхийн тухай гэрээ» /1958.4.11/, «Монцамэ, Синьхуа-гийн хооронд мэдээ солилцох тухай хэлэлцээр» /1958.6.2/, «БНМАУ ба БНХАУ-ын шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр» /1960.5.31/ зэргийг дурдаж болох юм.

Зарим гэрээ, хэлэлцээрүүдийн тухайлбал 1958 оны 2 дугаар сарын 21-ний өдөр Бээжин хотноо байгуулагдсан «БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр»-ийн оршилд *“...БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны тухай 1952 оны 10 дугаар сарын 4-нд байгуулсан хэлэлцээрийн хоёрдугаар зүйлийг үндэс болгож...”*¹² тухайн хэлэлцээрийг байгуулж буйгаа дурджээ. Улмаар салбар салбарт, бүр цаашлаад байгууллага хоорондын хамтын ажиллагааны механизмууд бүрдэж, хоёр улсын эдийн засаг соёлын салбарын хамтын ажиллагаа богино хугацаанд маш эрчтэйгээр өрнөн хөгжив.

Тийм суурьтай учраас БНХАУ-ын Ерөнхий сайд Жоу Эньлайн айлчлалын үеэр талууд 1960 оны 5 дугаар сарын 31-нд Улаанбаатар хотноо «БНМАУ, БНХАУ-ын хоорондын найрамдал, харилцан туслалцах гэрээ»-г байгуулсан юм. Энэ гэрээ бол дээр дурдсан олон хэлэлцээрүүд ба тэдгээрийн хэрэгжилтийн хүрсэн түвшинд суурилан тухайн цагийн хоёр улсын харилцааны ерөнхий зарчим, хэм хэмжээг тодорхойлсон чухал эрх зүйн баримт бичиг болсон билээ. Таван зүйлт энэ гэрээний дөрөвдүгээр зүйлд *“Хэлэлцэн тохирогч хоёр тал нь БНМАУ, БНХАУ-ын хооронд 1952 оны 10 дугаар сарын 4-ний өдөр байгуулсан эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах тухай Хэлэлцээрийн үндсэн дээр хоёр улсын хоорондын эдийн засаг, соёл, шинжлэх ухаан – техникийн хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэн бэхжүүлэхээ дахин тунхаглан мэдэгдэж байна”*¹³ хэмээснээс харахад уг гэрээнд бидний онцлон ярьж буй 1952 оны хэлэлцээрийн агуулга, үзэл санаа гүн гүнзгий шингэн орсон болохыг мэдэж болох байна.

¹² Монгол-Хятадын соёл шинжлэх ухааны харилцаа. Тэргүүн боть. УБ., 2021, тал 155. БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр. 1958.2.21. Бээжин хот.

¹³ Монгол-Хятадын соёл шинжлэх ухааны харилцаа. Тэргүүн боть. УБ., 2021, тал 231. БНМАУ, БНХАУ-ын хоорондын найрамдал, харилцан туслалцах гэрээ. 1960.5.31. Улаанбаатар.

Гуравдугаар зүйлд хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх хугацааны тухайд дурджээ. “Энэ хэлэлцээр нь батлагдсан өдрөөс эхлэн 10 жилийн турш хүчин төгөлдөр байх болно. ...Хэрэв хэлэлцэгч эрхэм хоёр этгээдийн аль нэг нь энэ Хэлэлцээрийн хугацаа дуусахаас нэг жилийн өмнө уг Хэлэлцээрийг цуцлах тухай саналаа илэрхийлэхгүй бол энэ Хэлэлцээр нь дараагийн 10 жилийн хугацаанд хүчин төгөлдөр болон үлдэнэ...”¹⁴ хэмээснээс хэлэлцээр 1962 оныг дуустал лав хүчинтэй үйлчилснийг харж болно. Харин хэлэлцээрийг цуцлах тухай саналыг талуудын аль нь ч хэлэлцээрийн хүчин төгөлдөр үйлчлэлийн хугацаа дуусахаас өмнө гаргаагүй тул аяндаа цааш 10 жилээр сунгагдаж, 1972 оныг дуустал хугацаанд хүчин төгөлдөр хэвээр үлдсэн байна. 1970-аад оны эхэн бол хоёр улсын харилцаа доод түвшинд унасан үе байв. Хятад, Зөвлөлтийн үзэл суртлын зөрөлдөөн зэвсэгт мөргөлдөөнд хүрэн хурцдаж байсан тухайн цагт Монгол, Хятадын харилцаа бараг тасраад байв. Гэсэн ч хоёр талаас дипломат санаачилга гарган ГЯЯ хооронд хэлэлцээрийн хүчин төгөлдөр хугацааг сунгах тухайд харилцан ноот солилцсон байдаг. Энэ бол 1972 оны 8 дугаар сарын 16-ны өдөр буюу хэлэлцээрийн хүчин төгөлдөр хугацаа дуусахаас 4 сарын өмнөхөн ажээ. Монголын А-185, Хятадын 第38/72 号 дугаарт тэрхүү ноот бичигт:

*“...БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны тухай 1952 онд гарын үсэг зурсан хэлэлцээр 1972 оны 12 дугаар сарын 29-ний өдөр хугацаа дууссаны дараа 10 жилийн хугацаанд үргэлжлэн хүчин төгөлдөр байна. Хэлэлцээрийн хугацаа дуусахаас 1 жилийн өмнө аль нэг тал нь цуцлах саналаа илэрхийлэхгүй бол дараагийн 10 жилд уг хэлэлцээр аяндаа хүчинтэй байх болно гэж Монголын/Хятадын тал зөвшөөрч байгааг энэхүү ноот бичгээр нотолж байна...”*¹⁵ гэжээ.

Энэ нь 1982 оныг дуустал, улмаар хоёр талаас тодорхой үйлдэл гаргахгүй байсан ч цааш аяндаа сунгагдаж 1992 оныг дуустал буюу Хүйтэн дайныг төгсгөж, шинэ уур амьсгал орсон он жилүүд хүртэл хэлэлцээрийг хүчинтэй байлгах үндэс болж, хоёр улсын хооронд гэрээ, хэлэлцээрүүд шинэчлэн байгуулагдах шинэ цаг үетэй золгож чадсан байна. Улмаар 1989 онд Засгийн газар хоорондын хэлэлцээрээр Эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан – техникийн талаар хамтран ажиллах Монгол-Хятадын комисс байгуулагдсан нь өнөөг хүртэл хоёр улсын харилцаанд чухал үүрэгтэй оролцдог хамтын ажиллагааны механизм болсоор байгаа юм.

¹⁴ Монгол-Хятадын соёл шинжлэх ухааны харилцаа. Тэргүүн боть. УБ., 2021, тал 25. БНМАУ ба БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр. 1952.10.4. Бээжин хот.

¹⁵ Гадаад харилцааны төв архив. Х-119, Д.1, ХН-114-4, хуудас 174-177.

Төгсгөл

1949-1960-аад оны эхэн хүртэлх арав гаруй жил бол Монгол, Хятадын харилцаа өдрөөс өдөрт өргөжин тэлсэн, хамтын ажиллагааны үйл явдлын нягтрал давтамж ихэссэн, өрнүүн хөгжлийг бүх салбарт дагуулсан он жилүүд байв. Энэ үеийг судлаачид Монгол, Хятадын харилцааны "Алтан арван жил" хэмээн онцолдог бөгөөд 1952 онд хоёр талын хамтын хүчин чармайлт, хүсэл эрмэлзлийн үр дүнд Засгийн газрын түвшинд байгуулсан «БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр» нь тэрхүү "Алтан арван жил"-д хурдтайгаар өргөжин тэлсэн Монгол, Хятадын харилцаа, хамтын ажиллагааны эрх зүйн суурь, үндэс байжээ.

Энэ хэлэлцээр нь Монгол, Хятадын харилцаа туйлын төвөгтэй байдалд хүрсэн он жилүүдэд ч хоёр талаас найрамдал, нөхөрлөлөө хадгалж үлдэх гэсэн хүсэл тэмүүлэл ямагт оршсоор ирсэн гэдэгт тод нэгэн баталгаа болж чадаж байна.

Цаг үе яаж ч өөрчлөгдсөн, засаглалын тогтолцоо яаж ч хувирсан энэхүү хэлэлцээр Монгол, Хятадын харилцаанд ач холбогдолтой байж, агуулга үзэл санаа нь өнөөдрийг хүртэлх хугацаанд хоёр улсын харилцааны хүрсэн түвшнийг бататгасан үе үеийн чухал баримт бичгүүдэд оршсоор байна.

Өнөөдрийн нөхцөлөөс харахад, «БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр» хийгээд түүнийг үндэс болгон байгуулагдсан тухайн үеийн Монгол, Хятадын харилцаа, хамтын ажиллагааг магадгүй Хятадын зүгээс хэрэгжүүлсэн "Зөөлөн хүч"-ний бодлогын амжилттай хэрэгжилтийн жишээ хэмээн үзэж, тайлбарлаж болох юм. Юу ч болсон БНМАУ энэхүү хэлэлцээрийн үр шимийг хангалттай хүртсэн гэж үзэх үндэстэйг нэг талаар, тус хэлэлцээрээс соёолон ургасан салбар салбарын гэрээ хэлэлцээрүүд хийгээд тэдгээрийн зүйл заалтуудын дагуу явагдсан хамтын ажиллагааны цар хүрээ, бодит үр дүнгүүд харуулна. Нөгөө талаар, монголчуудын хувьд социализмын жилүүдэд магадгүй хэт Зөвлөлтжих, хэт оросчлогдох том эрсдэлтэй тулж байсныг энэ хэлэлцээрийн үр дүнд буй болсон Монгол, Хятадын арав гаруй жилийн өрнүүн бөгөөд дотно харилцаа тодорхой хэмжээнд сааруулсан ба нэг тал руу хэт хэлбийсэн харилцаанд тэнцвэржүүлэх нөлөө үзүүлсэн байхыг үгүйсгэх аргагүй.

Иймийн тул илтгэлийн эхэнд дурдсан эргэлзээнд хариу болгоход, 1952 оны 10 дугаар сарын 4-ний өдөр байгуулагдсан «БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр»-ийг хоёр улсын харилцааны түүхэн дэх онцгой, хүндтэй байр сууринд тавьж, Монгол, Хятадын хооронд байгуулсан гол гол үйл явдал ба чухал гэрээ хэлэлцээрийн жагсаалтад ЗААВАЛ багтаан дурдаж байх ёстойг онцлон тэмдэглэе.

Ашигласан материал:

1. Гадаад харилцааны төв архив. Х-4, Д-19, ХН-381; Х-5, Д-2, ХН-89; Х-5, Д-2, ХН-184; Х-5, Д-2, ХН-85; Х-119, Д-1, ХН-114;
2. Монгол-Хятадын соёл шинжлэх ухааны харилцаа (1949-1965). Баримт бичгийн эмхэтгэл, тэргүүн боть. УБ., 2021.
3. БНМАУ-ын Гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхэтгэл. I боть. УБ. 1964
4. БНМАУ-ын Гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхэтгэл. II боть. УБ. 1966
5. Монгол-Хятад хоёр улсын түүхэн харилцааны он дараалсан лавлах (1949-2014) УБ., 2014.
6. Найрамдал, хамтын ажиллагааны нэгэн жаран. Бээжин, 2009.
7. Монгол, Зөвлөлтийн харилцаа. Баримт бичгийн эмхэтгэл (1921-1974). УБ., 1981
8. Монгол-Хятадын харилцааны түүхэн баримт бичгийн эмхэтгэл (1990-2010) УБ., 2014.
9. Д.Шүрхүү. Монгол Улс, БНХАУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээний улс төр, эрх зүйн ач холбогдол. Шинжлэх Ухааны Академийн мэдээ, 2014№3(211), тал 20-24.